

**2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ ТАЙЛАН**

1.БИЗНЕСИЙН ОРЧИН

Бизнесийн чиглэл

Оффис, агуулах, гараж болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйлчилгээ.

Компанийн танилцуулга

Тус компани нь 1992 онд “Гутал” ХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдаж, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэгт байрлах оффис, агуулах болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай объектуудыг түрээслүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн түрээсийн зориулалтаар ашиглаж буй үндсэн хөрөнгө нь үйлдвэр, гуанз, эмнэлгийн барилга, бусад жижиг барилгууд зэрэг нийт 40 гаруй объектоос бүрдэж байна.

Санхүүгийн байдал

“ГУТАЛ” ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг 2018 оны 8-р сараас “ФИНАНСТАКС” ТМЗ ХХК гэрээний дагуу хариуцан ажиллаж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, түүнтэй холбогдон Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн хатуу хөл хорио, бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зэрэг хориг арга хэмжээнүүд компанийн үйл ажиллагааны орлого буурахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээ.

Энэ нөхцөл байдалтай холбогдуулан гарсан нийгмийн даатгалын шимтгэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хуулиудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Уг нөхцөл байдал 2021 оны 7-р сарыг хүртэл үргэлжлэх төлөвтэй байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт /сая төгрөг/	2017	2018	2019	2020
Эргэлтийн хөрөнгө	3,590.6	3,995.3	4,876.0	4,445.9
Эргэлтийн бус хөрөнгө	8,073.8	7,878.7	8,156.7	8,322.6
Нийт хөрөнгийн дүн	11,664.6	11,874.0	13,032.7	12,768.5
Өр төлбөр	741.1	753.6	782.4	816.1
Эзэмшигчийн өмч	10,950.3	11,120.4	12,250.3	11,952.4
Нийт ӨТ ба ЭӨ-ийн дүн	11,664.6	11,874.0	13,032.7	12,768.5

Нийт хөрөнгийн 94.0 хувийг эзний өмч, 7.0 хувийг өр төлбөр эзэлж байна.

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд

“ГУТАЛ”ХК Жилийн үйл ажиллагааны тайлан 2020 он

2020 онд түрээслэгч нарт нийт 506.2 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт үзүүлж тухайн жилд ногдох ААНОАТ-ын 175.4 сая төгрөгийг чөлөөлүүлэн ирэх онуудад уг татвараар нөхөж авах 330.8 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө буюу авлага үүсээд байна.

Шинэчлэн найруулсан ААНОАТ-ын хуулиар барилга, байгууламж хөрөнгийг элэгдүүлэх хугацаа 40 жил байсныг 25 болгон өөрчилснөөс үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өссөн, инженер техникийн болон үйлчилгээний ажилчдын цалинг системтэйгээр нэмэгдүүлсэн зэргээс үйл ажиллагааны зардал өссөн үзүүлэлттэй байна.

2020 оны гүйцэтгэлээр 3,748.3 сая төгрөгийн орлоготой, 1,765.1 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан.

Орлогын төрөл /сая төгрөг/	2018 оны гүйцэтгэл	2019 оны гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл	Өсөлт +/- Бууралт -/-	Хувиар /%/
Түрээсийн орлого	3,945.1	4,122.7	3,672.5	-450.2	4.5
Хэвлүүрийн орлого	4.1	0	0	0	
Хүүгийн орлого	152.5	292.7	73.4	-219.3	2.2
Бусад орлого	0.2	50.4	2.4	-48.0	
Дүн	4,101.9	4,465.8	3,748.3	-717.5	7.2
Ханшийн зөрүүний олз, гарз		14.1	67.8	53.7	
Үйл ажиллагааны зардал	1,605.2	1,683.1	2,037.0	353.9	
Бусад зардал	7.8	110.8	7.4	-103.4	
ОАТ-ын зардал	255.9	282.5	7.3	-275.2	
Татварын дараах цэвэр ашиг	2,225.8	2,403.6	1765.1	-638.5	

2020 онд компанийн үйл ажиллагааны борлуулалтын орлого өнгөрсөн оноос 717.5 сая төгрөгөөр, хүүний орлого 219.2 сая төгрөгөөр буурч, үйл ажиллагааны зардал 353.9 сая төгрөгөөр өссөн боловч орлогын албан татварын зардал 275.2 сая төгрөгөөр, бусад зардал 103.4 төгрөгөөр хэмнэгдэж цэвэр ашгийн хэмжээ өнгөрөгч оныхоос 638.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Төлсөн татвар, шимтгэл

Тайлант жилд нэмэгдсэн өртгийн албан татварт 314.0, Нийгмийн даатгалын шимтгэлд 49.7, Хувь хүний орлогын албан татварт 6.1, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 118.0, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 79.6, нийт улс, орон нутгийн төсөвт 567.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төрөл /сая төгрөг/	2017	2018	2019	2020
НӨАТ	302.0	435.7	341.4	314.0
НДШ	103.0	101.9	105.4	49.7
ХХОАТ	526.0	224.4	160.3	6.1
ААНОАТ	230.0	267.5	276.3	118.0
ҮХЭХАТ	93.0	66.8	79.4	79.4
Нийт дүн	1,254.0	1096.3	962.8	567.2

2.ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн явуулахыг эрмэлзсээр ирлээ.

Түрээслэгч нарын түрээсийн авлагатай холбоотой хэрэг маргааныг өмгөөллийн “Монгол өмгөөлөгч” ХХН-тэй хамтран шүүх болон шүүхийн өмнөх шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэн ажиллаж байна.

Нийгмийн халамжийн асуудлаар холбогдох хууль тогтоомж, компанийн ТУЗ-ийн шийдвэрийг баримтлан тодорхой төлөвлөгөөтэй ажил зохион явуулахаар төлөвлөн хэрэгжүүлж ирлээ. Эдгээртэй холбогдон гарч буй зардлыг санхүүгийн төлөвлөгөөнд бүрэн тусгасан болно.

2020 онд Нийслэлийн татварын газраас компанийн 2016 оноос 2019 оны үйл ажиллагаанд татварын хяналт шалгалт хийж 1.3 сая төгрөгийн төлбөр ногдуулсан.

3.2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛГААНЫ ҮР ДҮН

“ГУТАЛ” ХК нь түрээслэгч болон харилцагч байгууллагуудын ая тухтай орчин, зөв боловсон харилцааг эрхэмлэн, компанийнхаа бүхий л үйл ажиллагааг хуулийн хүрээнд ил тод, нээлттэй шударга зарчмыг баримтлан, ажилчдынхаа нийгмийн асуудал, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхийг ямагт эрмэлздэг нь бидний өнөөдрийн амжилтын үндэс юм.

Мөн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ноогдох ногдол ашгийг жил бүр тогтмол олгосоор ирсэн бөгөөд энэ жилийн хувьд 50 орчим хувьцаа эзэмшигчид нийт 2,303.8 сая төгрөгийн ногдол ашиг олгосон байна.

Гүйцэтгэх удирдлагын зүгээс авч хэрэгжүүлсэн ажлууд

- Номин Реалтор ХХК-тай 2018 онд шийдсэн хөрөнгө оруулалтын гэрээний дагалдах гэрээ болох Номин Фүүд Коорт болон Номин Кидс-ийн гэрээний үнийн өөрчлөлтийг удаан хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэлээ.

- Covid-19 цар тахалтай холбогдуулан түрээсийн хөнгөлөлтийг шаардлагатай газруудад тухай бүр нь үзүүлсэн. Түрээсийн орлого 30 орчим хувиар буурсан ба төлбөрийн хүндрэлүүд нилээд үүсээд байна.

- ЭХЗХ-оос эрчим хүчний хэмнэлтийн үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд тусгай эрх бүхий байгууллагаар аудит хийлгэх шаардлага тавьсны дагуу холбогдох аудитыг хийлгэсэн.

- 60 гаруй жилийн өмнө барьсан 300 м² орчим талбайтай хуучин агуулахыг буулгаж суурин дээр нь 590 м² талбайтай шинэ агуулах барьж ашиглалтанд оруулан түрээслүүлж эхэллээ.

- Компанийн 21 жил болсон дулаан, цэвэр усны ерөнхий шугамыг өөрсдийн хүчээр сольж янзаллаа.

“ГУТАЛ”ХК Жилийн үйл ажиллагааны тайлан 2020 он

- Үндсэн байрны гадаа ашиглаж чадаагүй байсан газрыг сайжруулан 200 орчим м² авто зогсоолыг шинээр барьж ашиглалтанд орууллаа.
- Covid-19 цар тахлын дэгдэлттэй холбоотой эдийн засгийн хямралтай үед улсын төсөвт төлөх татвар, ажилчдын орон тоо болон цалин, түрээслүүлэх талбайн дүүргэлтийг аль болох бууруулахгүй байхыг эрмэлзэн ажиллаж байна.

3.ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

“ГУТАЛ” ХК нь 2020 онд захиргааны албанд 5, инженер техникийн албанд 6, барилгын албанд 4, харуулын албанд 12, аж ахуйн албанд 6 ажилтан, нийт 33 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулахаар төсөвлөсөн.

2020 онд ажилчдын ажлын үр дүнг сайжруулах, орон тооны илүүдлийг бууруулах зохистой арга хэмжээ авснаар нийт орон тоонд харьцуулбал цалингийн зардлын хэмжээг тодорхой хэмжээгээр хэмнэж ажилласан байна.

ГУТАЛ ХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ТУЗ

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

ЗАХИРГААНЫ

АЛБА

ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН

АЛБА

ХАРУУЛ, ХАМГААЛАЛТЫН

АЛБА